

ТОТТОРИ

ТАНЫ МЭДЭХГҮЙ
ЯПОН ОРОН

[АЯЛАЛЫН ХӨТӨЧ]



Гайхамшигт ТОТТОРИ



Тотторид аялцгаая

Тотторид хүрэлцэн ирэхэд Токиогоос онгоцоор 80 минут орчим, Осака, Киотогоос гал тэргээр ердөө хэдхэн цаг зарцуулна. Тоттори муж нь Япон тэнгис болон Чюүтоку бүс нутгийн дунд оршдог, байгалийн үзэсгэлэн бүрдсэн нутаг, бөгөөд шинийг эрэлхийлдэг аялагчдад үргэлж нээлттэй байдаг газар юм.



Одот тэнгэрийн дор цэлийх элсэн манхан,
бурхад оршдог хэмээн эртнээс шүтэж ирсэн
ариун дагшин уул, түүх соёлын дурсгалт
газар, эртний түүхтэй сүм хийд, улирлын
чанартай шинэхэн орц бүхий амтат зоог,
биечлэн туршиж үзэх сонирхолтой
хөтөлбөрүүд гээд зөвхөн Тотторид л харж
болох гайхалтай зүйлс нь манай нутгийг
зорих хангалттай шалтгаан билээ:

Та Тотторид ирвэл, таны мэдэхгүй Япон
орныг нээж олох болно.



Тоттори Таны адал явдалтай аялалын эхлэл.



09:00

Мизүки Шигэрүгийн гудамж

Энэ бол алдарт манга зураач Мизүки Шигэрүгийн зохиолд гардаг “Ёокай” буюу мангасуудын ертөнцөөр сэдэвлэн тохижуулсан газар. JR Сакайминато өртөөнөөс 800 метр орчим үргэлжлэх тус гудамжинд Мизүки Шигэрүгийн зохиолын баатар болох 177 баримлыг байршуулсан байдаг. Үдэш болж гэрэлтүүлэг асахад мангасуудын сүүдэр энд тэнд үзэгдэж, таныг өөр нэгэн өвөрмөц ертөнцөөр аялуулах болно.

©Mizuki Productions



13:00

Тоттори Ханакайро Цэцгийн хүрээлэн

Японы хамгийн том цэцгийн хүрээлэнгүүдийн нэгд тооцогдох Тоттори Ханакайро нь улирал солигдох бүр өнгө төрхөө шинэчилдэг цэцэгсийн диваажин юм. Тус цэцэрлэгийн онцлох цэцэг бол жилийн турш дэлгэн үзүүлдэг сараана. Японд хамгийн олон буюу 15 төрлийн сараана цэцгийг эндээс харж болно. Эндхийн бас нэгэн үзүүштэй зүйл бол 14,000 гаруй цэцэг бүхий 80,000 м2 талбайг гэрэлтүүлдэг шөнийн гэрлэн чимэглэл билээ.



Дахин давтагдашгүй ТОТТОРИГИЙН АЯЛАЛ

Тотторид хөл тавьсан эхний өдрөөс л гайхашрал төрүүлж байлаа. Байгалийн гоо үзэсгэлэн, түүх соёлын дурсгалт газрууд, мартагын аргагүй амтат зоог... Энэ бүгд бидний сэтгэлийг эзэмдэж, урьд өмнө төсөөлж ч байгаагүй цоо шинэ Япон орныг олж харсан юм.



15:00

Дайсэн уул

[Китанизава горхит хөндий]

Окү-Дайсэн уулын гүнд хоржигнон урсах горхи, эвэрлэг модон ой зэрэг унаган байгалийн үзэсгэлэнт төрхөөрөө алдартай Китанизава горхит хөндий бий. Энд ой хөвчөөр зугаалан анир чимээгүйд горхины хоржигноон, шувуудын жиргээг сонсох нь таныг яг л өөр ертөнцөд аваачсан мэт сэтгэгдэл төрүүлнэ. Жилийн аль ч улиралд ер бусын үзэсгэлэнтэй харагдах энэ газраас та тайвшрал болон урам зоригийг авах болно. Түүнчлэн хаврын улиралд шувуу ажиглах аялал, өвлийн улиралд цасны ултай аялал зэрэг хөтөчтэй аялал хийх боломжтой.

Аялалын 1 дэх өдөр

Бидний аялал эхэлсэн нь

Бидний аялалын эхний цэг Японы нэрт манга зураач Мизүки Шигэрүгийн гудамж байлаа. Дараа нь Тоттори Ханакайро цэцгийн хүрээлэнд зочилж, өнгө алаглах цэцгэн дундуур зугаалан, гүн улаан цэцгийн толгодоос дараагийн хүрэх цэг Дайсэн уулын цаст оргилыг тольдов. Харин гал улаан, алтан шаргал навчис хөглөрөх Китанизава горхит хөндийд очиход Дайсэн уулын үлгэрийн мэт үзэсгэлэнтэй төрх, байгаль эхийн өгөөмөр хишиг нь биднийг дахин ирэхийг урин дуудах мэт мэдрэмж төрүүлж байлаа.

Мизүки Шигэрүгийн гудамж

Баруун бүс

Газрын зураг 1

Тоттори-кэн, Сакайминато-ши, Тайшө-мачи-аас Хон-мачи хүртэл (JR Сакайминато өртөөнөөс 800 метр орчим үргэлжилнэ)



Тоттори Ханакайро Цэцгийн хүрээлэн

Баруун бүс

Газрын зураг 2

Тоттори-кэн, Сайхаку-гүн, Нанбү-чөо, Цүрүда 110



Дайсэн уул (Китанизава горхит хөндий)

Баруун бүс

Газрын зураг 3

Тоттори-кэн, Хино-гүн, Кофу-чөо, Оаза Мицүкүзү 837-13





09:00

Аояма Гошёогийн музейд Мөрдөгч Конантай уулзаарай!

Аояма Гошёогийн музей жуулчдыг татах сонирхолтой үзмэрүүдээр дүүрэн бөгөөд таныг Мөрдөгч Конан-ы манга, анимэ ертөнцөөр аялуулах болно. 2007 онд нээгдсэн тус музей дэлхийн өнцөг булан бүрээс ирэх зочидод олон орны хэлээр танилцуулгаа хийдэг онцлогтой.

©GOSHO AOYAMA/SHOGAKUKAN



11:00

Күраёши хотын Ширакабэ Дозогүн [Цагаан агуулахуудтай гудамж]

Күраёши хотын Ширакабэ Дозогүн бол Эдо, Мэйжи эрин үеийн хэв шинжийг агуулсан уламжлалт барилга байгууламж бүхий түүхийн чухал дурсгалт газар юм. Чулуун гүүр, улаан вааран дээвэр, цагаан хана бүхий барилга байгууламжийн гоёмсог зохицолыг өнөө үед тэр болгон олж харахгүй бизээ. Урьд өмнө шар айраг, цууны үйлдвэр ажиллаж байсан эдгээр барилгуудад одоо нутгийн гар урлалын бүтээгдэхүүний дэлгүүр, кафе, галлерей зэрэг худалдаа үйлчилгээний газрууд ажиллаж байна.



14:00

Митокү уул Санбүцүжи хийд

Митокү уулын эгц цавчим хадан дунд Санбүцүжи хийд оршдог. Энэ газрыг эртнээс ариун газар хэмээн шүтэж ирсэн бөгөөд уулын бартаат замыг туулж хийдийг зорин ирснээр бие болоод сэтгэлийн ариуслыг олдог гэж үздэг. Мөргөлийн аян замын эцэст цавчим хадан дунд орших мянга гаруй жилийн настай Нагэирэдо сүм таныг угтан авах болно.



Аялалын 2 дахь өдөр

Сонирхолтой ертөнцөөр аялсан нь

Аялалын 2 дахь өдөр Мөрдөгч Конан зохиолын эх зургууд болон сонирхолтой үзмэрүүдээр дүүрэн байдаг Аояма Гошёогийн музей байрших Конан Таун (Хокүэй сум)-аас аялалаа эхлүүлэв. Дараа нь тун сайн хадгалагдаж үлдсэн уламжлалт барилга байгууламж бүхий Күраёши хотын Ширакабэ Дозогүн гудамжаар зугаалахад яг л эртний Япон орноор цаг хугацааны аялал хийсэн мэт санагдаж байлаа. Үдийн хоолны дараа бид мөргөлчдийн тууз зүүгээд, бартаат замаар Митокү ууланд авирав. Ой шугуй дундуур огцом өгсүүр замаар явж, ариун дагшин газруудаар дайран өнгөрсний эцэст мянга гаруй жилийн настай архитектурын гайхамшигийг сая олж харсан юм.

Аояма Гошёогийн музейд Мөрдөгч Конантай уулзаарай!

Тоттори-кэн, Тохакү-гүн, Хокүэй-чёо, Юрашюкү 1414

Төвийн бүс

Газрын зураг 4



Күраёши хотын Ширакабэ Дозогүн (Цагаан агуулахуудтай гудамж)

Күраёши-ши, Тогия-мачи; Үо-мачи;
Хигашинака-мачи; Шинмачи 1-чёомэ

Төвийн бүс

Газрын зураг 5



Митокү уул, Санбүцүжи хийд

Тоттори-кэн, Тохакү-гүн, Мисаса-чёо, Митокү 1010

Төвийн бүс

Газрын зураг 6





09:00 *Тоттори “20-р зуун” лийрний музей*

Музейн үзмэрүүд болон мэдээллийн самбараас Тоттори мужийн онцлох бүтээгдэхүүн “20-р зуун” лийрний тухай бүгдийг мэдэх боломжтой. Музейн гол танхимд 20 метрийн өргөнтэй аварга том лийрний мод байрлах бөгөөд нутгийн бахархам туршлагыг өгүүлэх мэт сүр жавхлантай харагдана. Энд Тотторид тарьж ургуулсан 3 төрлийн лийрний амталгаат үйлчилгээг жилийн турш санал болгодгоос гадна лийрний зайрмаг, бэлэг дурсгалын зүйлс ч худалдан авах боломжтой.



16:30

Тоттори элсэн манхан

Тоттори элсэн манхан бол мужийн хамгийн алдартай аялал жуулчлалын цэг. 40 метрийн өндөртэй сүрлэг манхан яг л өргөн уудам элсэн цөлд очсон мэт сэтгэгдэл төрүүлднэ. Түүнчлэн Япон тэнгисийн салхиар зурагдсан элсэн хээ нь уран зургийг санагдуулам гайхалтай харагддаг. Энд явган аялал, параглайд, элсний дугуйн аялал, тэмээ унаж үзэх зэрэг төрөл бүрийн сонирхолтой хөтөлбөрүүд бий.




13:00

Үрадомэ эрэг

[Сан-ин эргийн Геопарк]

Үрадомэ эргийг чимэх дүнсгэр хад асга, нуман хэлбэртэй хадан цохио, сүрлэг агуй зэрэг нь Япон тэнгисийн олон мянган жилийн бүтээл билээ. Мөн зогсолтгүй хаялах далайн давалгааны нөлөөгөөр зөөлөн хийгээд дун цагаан элсэн эрэг үүсчээ. Зуны зугаатай далайн эргийн аялалд тохирох байгалийн төгс хослолыг эндээс л олно.



Аялалын 3 дахь өдөр

Сэтгэл сэргээж, нүд баясгах амтат хүнс

Аялалын 3 дахь өдөр “20-р зуун” лийрний музейгээс аялалаа эхлүүлэв. Музейд ердөө ганц цагийн дотор Тоттори мужийг төлөөлөх тэрхүү жимсний тухай төсөөлж ч байгаагүй их зүйлийг мэдэж авсан юм. Хамгийн сэтгэлд хоногшсон зүйл бол музейн ажилтаны найрсгаар танилцуулах нутгийн 3 төрлийн лийрний амталгаат үйлчилгээ байлаа. Бүгд уулга алдам сайхан амттай тул хамгийн амттайг нь сонгох тун хэцүү байсан юм. Дараа нь далайн эргийн хадан хясаа, хадан дээр ургасан царс мод, цагаан элсэн эрэг гээд байгалийн гайхамшгууд цогцолсон Үрадомэ эргээр зугаалав. Энэ өдрийн аялал Тоттори элсэн манхан дахь элсэн толгод руу авирснаар өндөрлөсөн. Элсэн толгодын орой дээрээс Япон тэнгисийн хаяанд нар жаргахыг ширтэн суух үнэхээр гайхалтай байлаа.

Тоттори “20-р зуун” лийрний музей
Тоттори-кэн, Кураёши-ши, Дакёжи-чёо 198-4

Төвийн бүс

Газрын зураг 7



**Үрадомэ эрэг
(Сан-ин эргийн Геопарк)**

Тоттори-кэн, Ивами-гүн, Ивами-чёо, Үрадомэ

Зүүн бүс

Газрын зураг 8



Тоттори элсэн манхан

Тоттори-кэн, Тоттори-ши,
Фүкүбэ-чёо, Юяма 2164-661

Зүүн бүс

Газрын зураг 9





10:00 *Ишитанигийн гэр музей*

Ишитанигийн өргөө Эдо эрин (1603-1868) үед цэцэглэн хөгжиж байсан Чизу суурингийн хамгийн том сууц байжээ. Цэлгэр том хашаа бүхий тус өргөө 40 өрөө, 7 агуулахтай. Сууцыг 20-р зууны эхээр сэргээн засварласан бөгөөд гүйдэг хаалга, дамнуур мод, уран зураг болон бусад чимэглэл нь Японы уламжлалт архитектурын үлгэр жишээ бүтээл учир соёлын чухал дурсгалт зүйлд бүртгэж авчээ.

Аялалын 4 дэх өдөр

Байгаль эхийн өгөөмөр хишгийг хүртэхүй

Тоттори дахь аялалын сүүлийн өдөр Ишитанигийн гэр музейгээс аялалаа эхлүүлэв. Энэ нь тухайн үеийн нэр цуутай айлын харш бөгөөд Японы архитектурын гайхамшигтай бүтээл. Өргөн цэлгэр цэцэрлэг нь орчлонгийн амар амгаланг мэдрүүлэх мэт үнэхээр гайхалтай. Дараа нь ойн гүнд байрших орчинтойгоо гайхалтай зохицсон Митаки-эн ресторанд үдийн зоог барилаа. Энд ойгоос түүж бэлтгэсэн орц бүхий амтат зоог, шувуудын жиргээ, байгалийн гоо үзэсгэлэнг нэг дор мэдэрч болно. Бидний аялалын сүүлийн зогсоол Оэносато Резортийн Кокогарден байв. Энэ бол өөрийн фермийн шинэхэн өндгөөр бэлтгэдэг, хөвсгөр зөөлөн шарвинг санал болгодог ресторан юм.

Ишитанигийн гэр музей

Зүүн бүс

Газрын зураг 10

Тоттори-кэн, Язү-гүн, Чизү-чёо, Чизү 396



Митаки-эн

Зүүн бүс

Газрын зураг 11

Тоттори-кэн, Язү-гүн, Чизү-чёо, Ашизү 707



Оэносато Резорт дахь Кокогарден

Зүүн бүс

Газрын зураг 12

Тоттори-кэн, Язү-гүн, Язү-чёо, Хашимото 877





12:30 Митаки-эн


Ойн гүнд орших Митаки-эн рестораны онцлогийг тодорхойлох зүйлс бол сүрлэн дэвэр бүхий уламжлалт сууц, задгай зуух, горхины хоржигноон. Мөн мэдээж улирлын чанартай уулын зэрлэг ногоогоор баялаг, эрүүл бас амттай зоог билээ. Энд зоогийн дараа хүрхрээний чимээг сонсож, үзэсгэлэнт байгаль дундуур зугаалахад ер бусын тайвшралыг мэдрэх болно.




15:00 Оэносато Резорт дахь Коккогарден

Оэносато Резорт бол байгальд ээлтэй фермийн аж ахуй юм. Эндхийн нэрийн хуудас болсон бүтээгдэхүүн бол торгүй орчинд тэжээдэг тахианы өндөг. Коккогардены улирлын чанартай орцоор хачирлаж бэлтгэдэг хөвсгөр зөөлөн шарвингийн гайхалтай амтны нууц нь энэхүү амтлаг бөгөөд тод шартай өндөг юм.

Аялалын маршрут





ХАВАР

Сакүра мод

Хавар бол Японы хамгийн гайхалтай улирал бөгөөд Тоттори мужийн цэцэрлэгт хүрээлэнгүүдэд үзэсгэлэнт сакүра цэцгийг үзэх боломжтой. Сакүра үзэхэд хамгийн тохиромжтой газруудын нэг бол Кураёши хотын Үцүбүки цэцэрлэг. Уулын бэлд орших уг цэцэрлэгт 4,000 орчим сакүра мод ургадаг бөгөөд цэцэрлэгийн цөөрөм, гоёмсог улаан гүүр нь модод цэцэглэх үеэр ер бусын уур амьсгалыг бүрдүүлдэг. Энд үдшийн цагаар дэнлүүнүүд асч бас нэгэн гайхамшигтай дүр зургийг бий болгоно. Харин Тоттори цайзын туурийн зэргэлдээ Мэйжи эриний шинэчлэлийг илтгэх түүхэн дурсгалт барилга Жинпүкаку хэмээх хоёр давхар цагаан харш бий. Харшийн эргэн тойронд сакүра мод ургадаг тул сакүра цэцэглэх үеэр тансаг байдал нь улам нэмэгдэх мэт үзэсгэлэнтэй харагддаг.

ЗУН

Гэрэлт цохтой үдэш

Тоттори мужийн зуны улирал сэтгэл татам зүйлсээр дүүрэн билээ. Тэдгээрийн нэг бол яах аргагүй Фүкүмаки цэцэрлэгийн гэрэлт цох юм. Нар жаргасны дараа 20,000 орчим гэрэлт цох гэрлээ анивчуулан бүжих нь үлгэрийн мэт үзэсгэлэнтэй.

Дайсэн уулын глэмпинг аялал

Сүүлийн үед дэлгэрээд буй глэмпинг (“glamorous camping” гэдэг үгээс үүсэлтэй) буюу тансаг зэрэглэлийн байгалийн аялалыг Дайсэнд хийх боломжтой. Энд төрөл бүрийн тохилог майхан, бүхээг, шүршүүр гээд тав тухтай орчиныг бүрдүүлэхэд шаардлагатай бүхий л зүйлс бий. Цаашилбал үзэсгэлэнт байгаль дунд зоог барингаа дарс шимж, дуу хөгжим сонсох боломжоор хангагдсан ресторан баар ч ажилладаг.

A. Үцүбүки цэцэрлэг
Тоттори-кэн, Кураёши-ши,
Накано-чёо

Төвийн бүс
Газрын зураг 13



B. Жинпүкаку
Тоттори-кэн, Тоттори-ши,
Хигаши-мачи 2-121

Зүүн бүс
Газрын зураг 14



C. Фүкүмаки гэрэлт цохын цэцэрлэг
Тоттори-кэн, Хино-гүн, Ничинан-чёо,
Фүкүмаки

Баруун бүс
Газрын зураг 15



D. Дайсэн дахь тансаг зэрэглэлийн байгалийн аялал
Тоттори-кэн, Сайхаку-гүн,
Хооки-чёо, Кобаяши 706

Баруун бүс
Газрын зураг 16



ДӨРВӨН УЛИРАЛ

Хавар, зун, намар, өвөл – эргэх дөрвөн улиралд өнгө өнгөөр солигдох үлэмж тансаг байгаль.



НАМАР

Гайхамшигт намрын навчис

Уул толгодын ногоон модод улаан, улбар шар, алтан шар өнгөөр хувирч Тотторид намар цаг ирснийг сануулна. Ожика хавцлын байгалийн гоо үзэсгэлэн жилийн турш гайхалтай ч намрын навчис хүрхрээ, хад асгыг чимэх үеэр онцгой үзэмжтэй харагддаг. Намрын өнгийг харж таашаал авах боломжтой бас нэгэн гайхамшигтай газар бол 1000 гаруй жилийн түүхтэй Дайсэн уулын Дайсэнжи хийд юм. Түүхэн дурсгалт архитектурын байгууламж, сүрлэг том хаалга, чулуун зам, горхины хоржигноонтой хослох намрын өнгө танд таалагдах нь гарцаагүй бизээ. Үдэш болоход хийдийн эргэн тойрны гэрэлтүүлэг асч, сүр жавхлантай энэ газарт амар амгаланг өгөх мэт сэтгэгдэл төрүүлнэ.

Е. Ожика хавцал

Тоттори-кэн, Тоохаку-гүн, Мисаса-чёо, Каннокура

Төвийн бүс

Газрын зураг 17



Е. Дайсэнжи хийд

Тоттори-кэн, Сайхаку-гүн, Дайсэн-чёо, Дайсэн 6

Баруун бүс

Газрын зураг 18



ӨВӨЛ

Үлгэрийн орон

Баруун Японы хамгийн алдартай цанын баазуудын нэг Дайсэн ууланд бий. Daisen White Resort зочиддоо 4 цанын замыг санал болгодог. Эндээс цасан дээлээ өмссөн Дайсэн уул, алсад харагдах Япон тэнгисийг тольдох боломжтой.

Өвлийн спортын диваажин

Хёносэн уул бол өвлийн спорт сонирхогчдын хувьд Баруун Японы хамгийн алдартай газруудын нэг юм. Уулын уруу буух мөчид өөдөөс угтах “мөсөн мангасууд” (цас мөсөөр хучигдсан модод) таныг уйдаахгүй гэдгийг дурдах нь зүйтэй.

Г. Дайсэн Вайт Резорт

Тоттори-кэн, Сайхаку-гүн, Дайсэн-чёо, Дайсэн 96

Баруун бүс

Газрын зураг 19



Н. Тоттори муж Вакаса сум Хёносэн цанын бааз

Тоттори-кэн, Язү-гүн, Вакаса-чёо, Цүкүён 631-13

Зүүн бүс

Газрын зураг 20





Элсэн баримлын музей

Энэ бол дэлхийн хамгийн анхны элсээр урласан уран баримлын музей. Тус музей 2012 онд байгуулагдсанаас хойш дэлхийн өнцөг бүрээс ирсэн уран бүтээлчдийн бүтээлүүдийг дэлгэн үзүүлж байна. Элсний шинж чанараас шалтгаалан эдгээр гайхамшигтай бүтээлүүдийг мөнх хадгалах боломжгүй ч, зөвхөн элсээр л илэрхийлж болох өвөрмөц мэдрэмжийг элсэн баримлуудаас харж болно. Музейн шилэн хана, гаднах тавцан дээрээс элсэн манхныг тольдох боломжтой.

Зүүн бүс

Газрын зураг 21

Тоттори-кэн, Тоттори-ши, Фүкүбэ-чёо, Юяма 2083-17



Тотторигийн тухай илүү ихийг эндээс



Күраёши фигурийн музей

Күраёши хотын уламжлалт цагаан агуулахуудын гудамжинд Күраёши фигурийн музей гэх орчин үеийн хэв загвар бүхий аялал жуулчлалын газар байдаг. Энд ан амьтан, үлэг гүрвэл, алдартай анимэ баатар зэрэг 2000 гаруй фигурийг дэлгэн үзүүлдэг. Музейн барилга нь сэргээн засварласан сургуулийн барилга бөгөөд өвөрмөц дугуй хэлбэртэй архитектур нь маш загварлаг харагддаг.

Төвийн бүс

Газрын зураг 24

Тоттори-кэн, Күраёши-ши, Кажи-мачи 1-2971-2



Дайсэн уулын бамбарын жагсаал

Жил бүрийн 6-р сарын эхний амралтын өдрүүдэд Дайсэн уулын зуны нээлтийн баяр зохиогддог ба энэ нь Тоттори мужийн улирлын чанартай арга хэмжээнүүдийн нэг юм. Оогамиама сүм дэх ёслолын дараа гартаа бамбар барьсан 2000 орчим оролцогч сүмийн тахилчийг даган уулнаас буудаг. Бамбарын цуваа яг л урсаж буй гал мэт харагдах нь маш сонирхолтой. Энэхүү өвөрмөц арга хэмжээнд хэн бүхэн оролцох боломжтой гэдгийг танд сануулья!

Баруун бүс

Газрын зураг 25

Тоттори-кэн, Сайхаку-гүн, Дайсэн-чёо, Дайсэн



Тоттори гар урлалын музей

1949 онд гар урлаач Ёшида Шёоягийн байгуулсан Тоттори гар урлалын музейд дэлхийн гар урчуудын 5,000 орчим бүтээлийг дэлгэн үзүүлдэг. Хэрэв та өвөрмөц бэлэг дурсгалын зүйл хайж байгаа бол музейн дэргэдэх Такүми гар урлалын дэлгүүрийг зориорой. Харин зоогийн газар хайж байгаа бол Такүми рестораныг зориорой. Энд Японы хамгийн сайн үхрийн махаар шалгарсан Тоттори вагюг боломжийн үнээр амтлах боломжтой.

Зүүн бүс

Газрын зураг 26

Тоттори-кэн, Тоттори-ши, Саказ-мачи 651





Хакүто сүм

Инабагийн цагаан туулайны тухай домогт туулай сүмийн голд байрлах Митарашин цөөрөмд шархаа угааж илааршсан тухай өгүүлдэг учир энэхүү ариун газрыг түлэгдэлт зэрэг арьсны өвчнийг намдаах хүчтэй гэж үздэг. Туулай домогт хайрын бурхны дүрээр гардаг тул 2010 онд Хакүто сүмийг дурлалт хоссуудын ариун газар хэмээн өргөмжилжээ.

Зүүн бүс

Газрын зураг 22

Тоттори-кэн, Тоттори-ши, Хакүто 603



Дайсэнгийн шүхэрт гэрэлтүүлэг

Зун Обон баяр (өвөг дээдсийнхээ сүнсэнд хүндэтгэл үзүүлэх баяр ёслол)-ын үеэр Дайсэнжи хийдээр зочилвол үгээр илэрхийлэхийн аргагүй гайхамшигтай дүр зургийг харах болно. Нар шингэж харанхуй болмогц хийдийн ойр орчимд байрлуулсан 120 гаруй Япон шүхрийг гэрлээр тусгаж, үлгэрийн юм шиг орчинг бүрдүүлсэн байх нь барилга байгууламжийн гоо үзэмжийг улам бүр нэмэх ажээ.

Гэрэл зургийг: Дайсэн аялал жуулчлалын газар

Баруун бүс

Газрын зураг 23

Тоттори-кэн, Сайхакү-гүн, Дайсэн-чөо, Дайсэн 9



Далайтай зэрэгцэн орших элсэн манхан, гайхалтай тогтоц бүхий далайн эрэг, балар ой шугуй гээд Японд өөр хаана ч байхгүй үзэсгэлэнт газруудыг Тотторид харж болно. Түүнчлэн Японы хамгийн эртний уран зохиол Кожики-д өгүүлдэг эртний сүм хийд, барилга байгууламж ч энд бий. Танд Тоттори мужийн баялаг түүх, соёлтой танилцаж, байгалийн гоо үзэсгэлэнг бие, сэтгэлээрээ мэдрэх боломжийг санал болгож байна.



Фүдоин Иваядо сүм

Байгалийн гаралтай агуй дотор барьсан Фүдоин Иваядо сүмийг Дайдо (806-810) эрин үед барьж босгосон гэж үздэг. 16-р зууны үед Тоётоми Хидэёши тус газар луу довтлох үеэр гал түймэрт нэрвэгдэх аюулаас аврагдсан цөөхөн барилгуудын нэг нь уг сүм юм. Сүмийг Фүдомёо (Буддын шашны таван мэргэн хааны нэг) хааны хөшөө гамшигт үзэгдлээс хамгаалсан гэж яригддаг.

Зүүн бүс

Газрын зураг 27

Тоттори-кэн, Язү-гүн, Вакаса-чөо, Иваядо



Одот тэнгэрийн доорх аялал

Японы хамгийн гайхалтай шөнийн тэнгэрийг үзэх боломжийг бүү алдаарай. Энэхүү үе үе зохион байгуулагддаг аялал таныг анивчин гялалзах одот тэнгэрийн доор Дайсэн уул руу хөтөлж, маш романтик гэрэл зургуудыг авах төгс боломжийг олгодог оронцол юм. Аялалыг сард 2-3 удаа зохион байгуулдаг бөгөөд улирал, цаг агаарын байдлаас шалтгаалан өөр өөр байгалийн үзэмжийг таашаах боломжтой.

Гэрэл зургийг: Дайсэн Аялал жуулчлалын байгууллага

Баруун бүс

Газрын зураг 28

Тоттори-кэн, Сайхакү-гүн, Дайсэн-чөо, Дайсэн



Итайбара тосгон

Чизү орчмын уулсаар хүрээлэгдсэн байгаль дунд Итайбара тосгон оршдог. Энэхүү суурин соёлын өв болох уламжлалт барилга байгууламжийг маш сайн хадгалж үлдсэн ховорхон газруудын нэг юм. Энд сэргээн засварлалт хийгдсэн Эдо (1603-1868), Шёва (1926-1989) эрин үеийн барилгуудад кафе, дэлгүүрүүд үүдээ нээн ажиллаж байна.

Зүүн бүс

Газрын зураг 29

Тоттори-кэн, Язү-гүн, Чизү-чөо, Ичиносэ, Итайбара





Япон шүхрийн урлан: Уламжлалт аргаар Япон шүхэр хийж үзэцгээе

Эдо эрин үед дэлгэрч байсан вагаса буюу Япон шүхрийг мод болон тослосон цаасаар хийдэг бөгөөд уран нарийн, гоёмсог хийц нь өнөө хүртэл хүмүүсийн сэтгэлийг татсаар байна. Та энэхүү шүхрийг өөрийн гараар урлаж, Японы уламжлалт соёлыг дурсгал болгон гэртээ авч хариарай.

Баруун бүс

Газрын зураг 30

📍 Тогтори-кэн, Ёнаго-ши, Ёдоэ-чёо, Ёдоэ 796



Үэда Шёожигийн гэрэл зургийн музей: Нэрт гэрэл зурагчийн бүтээлтэй танилцацгаая

Тогтори мужийн баруун бүсэд уулаар хүрээлэгдсэн тал газар Үэда Шёожигийн гэрэл зургийн музей оршдог. Энд нэгэн эринийг хальсандаа буулгасан Үэда Шёожигийн гайхалтай бүтээлүүдийг үзэх боломжтой. Тэрбээр Тогтори элсэн манханг фон болгон харуулсан ер бусын бүтээлүүдээрээ дэлхийд алдаршжээ. Тус музей дайнаас хойшхи Японы энгийн хүмүүсийн амьдралыг дүрсэлсэн сэтгэл хөдлөм, сюрреалист бүтээлүүдээр дамжуулан хүмүүсийг бодол эргэцүүлэлд хөтлөдөг юм.

Баруун бүс

Газрын зураг 31

📍 Тогтори-кэн, Сайхаку-гүн, Хооки-чёо, Сүмүра 353-3



Тотторид хийж болох аялалын санаанууд



Дайсэн уулын бэлээр аялах дугуйн аялал

Хээрийн аялал сонирхогчдод Дайсэн уулын бэлээр дугуйтай аялал хийхийг санал болгож байна. Энд туршлагатай дугуйчид тусгайлан зассан замаар эсвэл бартааг замаар уулын дугуйгаар аялах боломжтой. Мөн илүү чөлөөтэй, тайван аялахыг хүсч буй хүмүүст ч сонголт бий. Тодруулбал фермийн аж ахуйтай танилцаж, байгалийн сайханд саатан амрах боломж бүхий анхлан аялагчдад зориулсан маршрут бий.

Баруун бүс

Газрын зураг 33

📍 Тогтори-кэн, Сайхаку-гүн, Дайсэн-чёо, Акамацү 634



Хакота хүүхэддэйн урлан

Олон зууны туршид Хакота хүүхэддэйг хүүхдэд сахиус болгон өгдөг байжээ. Энэ хүүхэддэйг зөвхөн Күраёши хотод урладаг гэдгээрэй онцлог. Аянд яваа худалдаачин эр Күраёши хотод нэгэн бүсгүйтэй учирч, түүний даруухан, энгийн төрхөнд татагдан бүсгүйг дууриалган хүүхэддэй хийснээр энэ уламжлал эхэлжээ. Та хүүхэддэйн урланд хүүхэддэйн нүүрийг зурж будан өөрийн гэсэн хүүхэддэй урлаад гэртээ авч хариарай. Тэр таныг үргэлж хамгаалах болно.

Төвийн бүс

Газрын зураг 34

📍 Тогтори-кэн, Күраёши-ши, Үомачи 2529



Күраёши дахь кимонотой аялал: Цаг хугацааг ухраацгаая

Тогтори мужийн төвийн бүсэд орших Күраёши хот нь уламжлалт гар аргаар нэхсэн цагаан хээ угалз бүхий сэрүү татам индиги өнгийн Касүри давуугаараа алдартай. Дэгжин бөгөөд биед эвтэйхэн Касүри кимоног өөрийн сонголтоор өмсөөд, түүхэн дурсгалт Ширакабэ Дозогүн гудамжаар зугаалаарай. Жинхэнэ нутгийн иргэн шиг кимоно өмсөж, хүрээлэн буй орчиндоо уусан зохицоноор танд цаг хугацааг ухраасан мэт санагдах болно.

Төвийн бүс

Газрын зураг 35

📍 Тогтори-кэн, Күраёши-ши, Үомачи 1-2568





Лийр түүх аялал: Тотторигийн жимсийг амталж үзэцгээ

Тоттори муж нь “20-р зуун” сортын лийрний Японы №1 үйлдвэрлэгч гэдгээрэй алдартай. Мэдээж шинэхэн жимсэнд дуртай хүмүүст тэрхүү лийрийг модноос нь түүж идэх хүсэл төрөх нь дамжиггүй. Тэгвэл жимсний аж ахуйг зорьсноор хүсэл тань биелэнэ гэдгийг дурдая. Боловсорч гүйцсэн чихэрлэг, шүүслэг, шаржигнасан амттай лийр таныг гайхшруулах болно. Харин та аялалд гарахаасаа өмнө лийрний улирал таарч байгаа эсэхийг нягтлаарай.

Нийт нутгаар

Олон байршилд сонголттой



Фүрүсато Кэнкомүра: Өөрийн гараар ваар хийцгээ

Нэгэн самүрай эрийн зүүдэнд Бодьсадва ирж, цагаан чоныг нь аварсны хариуд Мисаса халуун рашааны байршлыг зааж өгсөн хэмээн домогт өгүүлдэг. Уг домгоос үүдэн тус газрын шаврыг ашиглан хийдэг Хакүро-яки (үгчилбэл “цагаан чонын вааран урлал”) нэртэй вааран эдлэлийн өвөрмөц хийц бий болсон гэдэг. Та энд нутгийн урчуудын заавраар өөрийн гараар ваар урлах боломжтой ба хэрэв хүсвэл бэлэг дурсгалын зүйл худалдан авч дурсамжаа нэгээр нэмээрэй.

Төвийн бүс

Газрын зураг 32

Тоттори-кэн, Тоооакү-гүн, Мисаса-чөо, Ёкотэ 15-1



Байгалийн гайхамшгууд цогцолсон Тоттори мужид төрөл бүрийн сонирхолтой аялал хийнгээ Японы эртний түүх, соёлыг ч таньж мэдэх боломжтой. Үе уламжлан ирсэн гар урлалыг өөрийн гараар туршин үзэж, уламжлалт соёлыг таван мэдэрхүйгээрээ мэдрэх сонирхолтой хөтөлбөрүүд таны аялалд амт нэмэх болно.



Аоя ваши цаасны урлан: Япон цаасаар урлацгаая

Иншюү ваши цаас нь үндэсний нэр хүндтэй зохиолч, уран бичээчдийн талархлыг маш ихээр хүлээдэг. Мөн удаан эдэлгээгээрээ алдартай тул эрт үеэс түүхэн бичвэрүүдэд ашиглаж иржээ. Та энэхүү цаасанд нуугдаж буй гайхамшигт чанарыг нутгийн гар урчуудаас суралцаж болно. Харин дараа нь тэрхүү уламжлалт арга технологиор өөрийн гэсэн Иншюү ваши цаасыг урлаарай.

Зүүн бүс

Газрын зураг 36

Тоттори-кэн, Тоттори-ши, Аоя-чөо, Яманэ 313



Ватанабэ дүрслэх урлагийн музей

Самүрайн хуяг, дуулга, сэлэмний цуглуулгыг дэлгэдэг тус музейд та самүрайн эрин үеэр аялах болно. Энд мөн нутгийн эмч Ватанабэ Хажимэгийн 60 жилийн турш цуглуулсан Хятадын дүрслэх урлагийн бүтээл, керамик эдлэл, Буддын шашны бүтээл зэрэг Дорно дахины 30,000 орчим эртний эд зүйлсийг дэлгэн үзүүлдэг. Самүрайн жинхэнэ хуяг, дуулгыг энд ердөө 1,000 иенээр өмсөж үзэх боломжтой.

Зүүн бүс

Газрын зураг 37

Тоттори-кэн, Тоттори-ши, Какүжи 55



Ойн эмчилгээ

Тотторигийн унаган байгаль дунд бие болоод сэтгэлийн тайвшралыг олж авах боломж бий. Та хөтчийн тусламжтайгаар өдөр тутмын амьдралын стрессээс холдож, өөрөө өөртэйгөө “танилцаж”, байгаль эхийг танин мэдэх болно. Түүнчлэн шөнийн ойн чимээг сонсож, амар амгалан, тайван орчинд бясалгал хийх зэргээр цагийг сонирхолтой өнгөрүүлэх боломжтой.

Зүүн бүс

Газрын зураг 38

Тоттори-кэн, Язү-гүн, Чизү-чөо





Цасан хавч (Мацүба хавч, Бэни-зүвайгани хавч)

Дэлхийн хамгийн эрэлттэй тансаг зэрэглэлийн хүнс бол чихэрлэг, шүүслэг цасан хавч. Нутгийн боомтод буусан шинэхэн цасан хавчийг Тоттори мужийн өвлийн онцлох хүнс гэдэг. Тотторигийн цасан хавчны төрөл зүйл гэвэл Мацүба, Бэни-зүвайгани-г дурдаж болно. Шарж, чанаж болгосон эсэхээс үл хамааран шүүслэг зөөлөн махны амт нь далайн хоолонд дурлагдахад гарцаагүй таалагдах бизээ.

Нийт нутгаар

Олон байршилд сонголттой



Тоттори мужийн амтат хүнс



“Daisen G Beer” шар айраг

Daisen G Beer компани цэвэр тунгалаг, амтлаг чанараараа алдартай Дайсэн уулын байгалийн булгийн усаар олон төрлийн шар айраг үйлдвэрлэдэг. Daisen G Beer “Weizen” шар айраг нь 2011 онд World Beer Awards буюу дэлхийн зөвхөн шилдэг шар айргуудад олгодог, хамгийн нэр хүндтэй шагналыг хүртжээ. Зөөлөн бөгөөд онцгой сайхан амттай, ямар ч хоолтой гайхалтай зохицдог Тотторигийн нутгийн шар айргийг заавал амталж үзээрэй.

Баруун бүс

Газрын зураг 40



Тоттори-кэн, Сайхаку-гүн, Хооки-чёо, Марүма 1740-30



Дайсэн сүүний орон

“Дайсэн Макиба сүүний орон” нь цөцгий амтагдсан зөөлөн зайрмаг амтлах зуураа нүдний өмнө цэлийх Япон тэнгис, үзэсгэлэнт Дайсэн уулыг тольдох жаргалтай мөчийг санал болгодог. Энд нутгийн малын мах, сүүгээр бэлтгэсэн амтат зоог, барбекью шарсан махаар үйлчилдэг ресторан, Тотторигийн алдартай бүтээгдэхүүнийг худалдаалдаг дэлгүүр ч бий.

Баруун бүс

Газрын зураг 41



Тоттори-кэн, Сайхаку-гүн, Хооки-чёо, Кобаяши, Мизүнашихара 2-11



Үхрийн ясны шөлтэй рамэн, Тоттори бургер

Тоттори бол маханд дурлагсдын диваажин. Та үхрийн ясны шөлтэй рамэн гоймонг заавал амталж үзээрэй. Онцгой сайхан амт үнэртэй үхрийн ясны шөл таныг баярлуулах нь дамжиггүй. Түүнчлэн шүүслэг бөгөөд дээд зэргийн чанартай махаар бэлтгэдэг Тоттори бургер зэрэг амтат зоогийн маш олон сонголт бий.

*Бодит бүтээгдэхүүн нь гэрэл зургаас ялгаатай байж болно.

Нийт нутгаар

Олон байршилд сонголттой





Тоттори Вагю үхрийн мах

Уулга алдам зөөлөн сайхан амттай Тоттори Вагю үхрийн махыг заавал амталж үзээрэй. Тотторигийн нэрийн хуудас болсон Тоттори Вагю үхрийн махыг зуу гаруй жилийн өмнөөс үйлдвэрлэж иржээ. Тоттори Вагю үхрийн махны аманд хайлах мэт зөөлөн шүүслэг чанар нь хамгийн өндөр чанартай тос болох олейн буюу ханаагүй тосны хүчлийг 55%-аас дээш хэмжээгээр агуулдаг оршино.

[Нийт нутгаар](#)

📍 Олон байршилд сонголттой



Сакайминато загасны зах

Далайн хоолонд дурлагсдал Баруун Японы хамгийн хөл хөдөлгөөнтэй загасны зах Сакайминато зорихыг санал болгож байна. Хавч, туна зэрэг шинэхэн далайн бүтээгдэхүүнийхээ хэмжээгээр улсдаа дээгүүрт ордог тус захын худалдаа наймааны дүр зургийг заавал сонирхож үзээрэй. Эндхийн наймаачидтай найрсаг яриа өрнүүлэн шинэхэн бүтээгдэхүүний амталгаа хийх боломжтой. Мөн таалагдсан бүтээгдэхүүнээ худалдан авч, оройн зоогоо бэлтгэж ч болох юм.

[Баруун бүс](#)

[Газрын зураг 39](#)

📍 Тоттори-кэн, Сакайминато-ши, Шёвомачи 9-5



Тоттори бол далайн хоолонд дурлагсдын диваажин гэхэд хилсдэхгүй. Та өвлийн улиралд шүүслэг Мацуба цасан хавч, зуны улиралд Ивагаки хадны хясааг амтлах боломжтой. Түүнчлэн аманд хайлах мэт зөөлөн үхрийн махаар бэлтгэдэг дээд зэргийн амттай бургер, тансаг хоолонд дурлагсдыг баярлуулах халуун тогоо зэрэг амтат зоогийн өргөн сонголтүүд бий.



Ивагаки хадны хясаа

Ивагаки хадны хясаа бол Тотторигийн зуны онцлох бүтээгдэхүүн. “Далайн сүү” гэгддэг уг хясааг уламжлалт аргаар агнадаг бөгөөд шим тэжээлээр баялаг төдийгүй аманд хайлах мэт зөөлөн, шүүслэг, мах ихтэй гэдгээрэй онцлог. Агнуурын оргил үе нь зуны эхэн сараас 8-р сарын дунд үе хүртэл үргэлжилдэг тул энэхүү богинохон хугацаанд л хадны хясааны тансаг амтыг мэдрэх боломжтой. Танд шинэхэн хясаан дээр нимбэгний шүүс шахаж түүхийгээр нь зооглохыг зөвлөө.

[Нийт нутгаар](#)

📍 Олон байршилд сонголттой



Хөх туна загас

Далай тэнгисийн хаан гэгддэг хөх туна загас бол Тоттори мужийн онцлох бүтээгдэхүүн. Сакайминато боомтод буудаг хөх туна загас нь баялаг амт чанараараа алдартай. 6 – 8-р сар хүртэл Японы хамгийн том хөх туна загаснууд тус боомтод бууж, алдарт Сакайминато загасны зах дээр худалдаалагддаг. Энэхүү дээд зэргийн туна загаснаас хаях зүйл бараг гардгүй бөгөөд шинэхэн сашими хийхээс аваад рамэн гоймон зэрэг орон нутгийн амтат зоогийг бэлтгэхэд ашигладаг.

*Бодит бүтээгдэхүүн нь гэрэл зургаас ялгаатай байж болно. Гэрэл зургийг: Кароко

[Нийт нутгаар](#)

📍 Олон байршилд сонголттой



Тоттори мужийн идээний дээж Сакэ

Тотторигийн хамгийн өндөр оргилуудаас эхтэй эрдэс бодисоор баялаг усаар хийдэг нутгийн сакэ бүр өөрийн гэсэн тансаг амттай. Тэдгээрийн дундаас Дайсэн уулын бэлд үйлдвэрлэдэг Күмэзакура, нэгэн цагт устаж үгүй болж байсан Гоорики сортын будаагаар хийдэг Хиокизакүра, халааж уухад тохиромжтой Бэнтэн Мүсүмэ зэрэг сархдыг заавал амталж үзээрэй.

Гэрэл зургийг: Ямамасү Сакэтэн

[Нийт нутгаар](#)

📍 Олон байршилд сонголттой





Мисаса халуун рашаан

Мисаса халуун рашаан анагаах чадвараара алдартай бөгөөд радоны өндөр агууламжтай тул бодисын солилцоог эрчимжүүлж, дархлааг сайжруулдаг увидастай. Энд Митокү голын эрэг дагуу байрлах уламжлалт рёкан буудлууд, нам гүмхэн гудамж, сэтгэл татам Кажика, Койтани гүүрнүүд гээд хуучны хэв шинжийг агуулсан газруудаар зугаалахад маш тааламжтай. Мөн нар шингэсний дараа гудамжны гэрэлтүүлэг асахад ид шидийн мэт уур амьсгалыг бүрдүүлдэг билээ.

Гэрэл зургийг: Тоттори муж

Төвийн бүс

Газрын зураг 42

📍 Тоттори-кэн, Тоохаку-гүн, Мисаса-чёо



Кайкэ халуун рашаан

Алсад тодрох Дайсэн уул, тэнгисийн эргээр эгнэх ногоон царс модод, нар мандахыг харахад хамгийн тохиромжтой Японы 100 шилдэг газрын нэгээр шалгарсан зэрэг нь тус рашааны тансаг байдлыг тодорхойлдог. Кайкэ халуун рашаан мэдрэлийн өвчин, арьсны өвчин, цус багадалтанд үр дүнтэй. Түүнчлэн Сан-ин бүсийн төв хэсэгт оршдог тул Тоттори болон Шиманэ мужийн аль ч чиглэл рүү аялахад тохиромжтой байршилд байдгаараа давуу талтай.

Гэрэл зургийг: Токоэн

Баруун бүс

Газрын зураг 43

📍 Тоттори-кэн, Енаго-ши, Кайкэ Онсэн



Тотторид тухлан амраарай



Сэкиганэ халуун рашаан


Дайсэн уулын бэлд орших Сэкиганэ халуун рашаан бол дэлхий дээрх радигийн өндөр агууламжтай цөөхөн халуун рашааны нэг бөгөөд ревматизм, мэдрэлийн өвчин, тулай, цусны даралт ихсэх, судас хатуурах өвчинд үр дүнтэй гэгддэг. Эрдэс бодисын өндөр агууламжтай хэдий ч ус нь тунгалаг бөгөөд үнэргүй тул “Цагаан алтан ус” ч гэж нэрлэдэг. Энд өдрийн аялал эсвэл нэг хоногийн аялал хийхэд тохиромжтой.

Гэрэл зургийг: Юмэйкан

Төвийн бүс

Газрын зураг 46

📍 Тоттори-кэн, Кураёши-ши, Сэкиганэ-чёо



Ивай халуун рашаан

1200 гаруй жилийн түүхтэй Ивай халуун рашаан Сан-ин бүс дахь хамгийн эртний рашаан тул уламжлалт модон барилгууд нь түүх өгүүлэх мэт харагддаг. Энд Эдо (1603-1868) эрин үеэс уламжилж ирсэн нэгэн сонирхолтой заншил бий. Энэ нь рашаанд орохдоо дуу дуулж, модон шанагаар толгой дээрээ халуун рашаан цутгах үйлдэл юм. Та туршаад үзээрэй.

Гэрэл зургийг: Тоттори муж

Зүүн бүс

Газрын зураг 47

📍 Тоттори-кэн, Ивами-гүн, Ивами-чёо



Шикано халуун рашаан

Сэнгокү (1467-1600) эрин үеийн Яманака Шиканосүкэ гэх алдар цуутай самурайн нэрээр нэрлэгдэх тус рашаан эртний цайзын туурийн ойролцоо, уулаар хүрээлэгдсэн нам гүмхэн газар оршдог. Шикано рашаан арьсны гоо сайханд тустай учир “Бүсгүйчүүдийн ус” гэх нь ч бий. Өдрийн аялалын дараа Хот Пиер Шикано рашаант буудалд амарч, эсвэл Санши-эн рашаант буудлын хөлийн халуун рашаант үнэ төлбөргүй алжаалаа тайлж болно.

Гэрэл зургийг: Санши-эн

Зүүн бүс

Газрын зураг 48

📍 Тоттори-кэн, Тоттори-ши, Шикано-чёо





Хавай халуун рашаан

Үзэсгэлэнт Того нуурын дээгүүр хөвж буй мэт харагдах Хавай халуун рашааны гоёмсог барилгууд жилийн аль ч улиралд ер бусын үзэсгэлэнтэй. “Кой-н ус” гэж нэрлэгддэг (Японоор “мөрөг”, “хайр” гэсэн утгатай) нь учиртай бөгөөд гадаад ертөнцөөс тусгаарлагдсан мэт романтик уур амьсгалыг бүрдүүлсэн орчин нь залуу хосуудад ихэд таашаагддаг. Тус рашаан мэдрэлийн өвчин, үе мөчний өвчинг намдаах үр дүнтэй.

Гэрэл зургийг: Бокоро

Төвийн бүс

Газрын зураг 44

Тоттори-кэн, Тоохаку-гүн, Юрихама-чёо



Того халуун рашаан

Того халуун рашаан Того нуурын зүүн өмнөд эрэгт оршдог бөгөөд эргэн тойрны байгалийн үзэмж нь Сан-ин бүсийн үзэсгэлэнт найман газрын нэгээр тодорчээ. Эндхийн рашааныг “Хайрын ус” хэмээн ярихаас гадна эсэн мэнд амаржих хүч чадал хайрладаг гэлцдэг. Хаврын сакура цэцэг, зуны наадам, баярын салют, намрын гоёмсог навчис, өвлийн шүүслэг Мацүба хавч гээд энд үзэж харах зүйл маш их.

Гэрэл зургийг: Ёзокан

Төвийн бүс

Газрын зураг 45

Тоттори-кэн, Тоохаку-гүн, Юрихама-чёо



Тотторид бие, сэтгэлийг сэргээж, алжаал тайлах тансаг барилга байгууламж бүхий 10 халуун рашаантай газар бий. Тухайлбал бодисын солилцоог эрчимжүүлэн, дархлаа сайжруулж, бие махбодийн өөрийгөө анагаах чадварыг дээшлүүлдэг дэлхийд алдартай радонтой халуун рашааныг дурдаж болно. Та өөрийн таашаалд нийцүүлэн сонголтоо хийж, халуун рашаанд тухлан саагаарай.



Тоттори халуун рашаан

Ундарга нь Тоттори мужийн захиргааны ойролцоо оршдог тус рашаан нь Тоттори өртөөнөөс 5 минутын зайд орших байгууламжуудыг халуун рашаанаар хангадаг. Хэдийгээр орчин үеийн барилгуудаар хүрээлэгдсэн ч тэдгээр байгууламжид хөл тавих мөчид таныг өөр ертөнцөөр аялуулах болно. Мөн найрсаг уур амьсгалыг бүрдүүлсэн байх тул бизнесмэн, жуулчдаас эхлээд зочидын хөл тасардаггүй.

Гэрэл зургийг: Кансүйтэй Козэния

Зүүн бүс

Газрын зураг 49

Тоттори-кэн, Тоттори-ши



Ёшиока халуун рашаан

1000 гаруй жилийн түүхтэй Ёшиока халуун рашааныг анх 962 онд Ёшиока гэх эр олж нээжээ. Арьсны өвчнөөр шаналж байсан охин нь тус рашаанд орж илааршин, гоо үзэсгэлэн нь сэргээсэнд тэрбээр рашааны хүчийг ихэд гайхан биширчээ. Хожим Эдо эриний үед Икэда овгийн ноёд ойр ойрхон рашаанд ирж амардаг байсан гэлцдэг. Тус рашаан одоо ч арьсны гоо сайханд тустай гэдгээрэй алдартай бөгөөд энд жил бүрийн 4-р сард Цэцгийн баяр, 6-р сард Гэрэлт цохны баярыг үзэх боломжтой.

Гэрэл зургийг: Ёшиока халуун рашааны танхим Ичино-ю

Зүүн бүс

Газрын зураг 50

Тоттори-кэн, Тоттори-ши, Ёшиока Онсэн-чёо



Хамамүра халуун рашаан

“Цагаан дэглийн рашаан” гэх нэрээр олонд танигдсан Хамамүра рашаан 500 гаруй жилийн түүхтэй. Нутгийн нэгэн домогт шархадсан цагаан дэглий уг рашаанд орж илааршсан тухай өгүүлдэг учраас ийнхүү нэрийддэг ажээ. Япон тэнгисийн эрэг дагуу орших энэхүү рашаан бие махбодийг залуужуулдаг гэдгээрэй алдартай бөгөөд эндээс цагаан элсэн эрэг бүхий тэнгисийн үзэмж гайхалтай сайхан харагддаг.

Гэрэл зургийг: Тоттори мужийн Кино зургийн холбоо

Зүүн бүс

Газрын зураг 51


Тоттори-кэн, Тоттори-ши, Кэтакэ-чёо



Тотторид хэрхэн ирэх вэ?


[Зам харилцаа]

Японы аль ч том хот, нисэх буудлаас Тотторид ирэхэд хялбар байх болно. Та дараах газрын зураг болон схем зураг дээрээс Тотторид хэрхэн явж ирэхээ тооцоолж болох ба тус гарын авлагад танилцуулсан газруудын байршлыг харах боломжтой. Түүнчлэн аялалын тооцоот хугацаа нь төгс аялалын маршрут төлөвлөхөд тань туслах болно.



- Тотторигийн аялал
- Хавар
- Зун
- Намар
- Өвөл
- Үзвэр
- Биечлэн турших хөтөлбөр
- Амтат хүнс
- Алжаал тайлах газрууд

Тотторид дахь аялалын тооцоот хугацаа



Нисэх буудлын машин түрээсийн мэдээлэл

ORIX
Rent-A-Car

Тоттори нисэх буудал

Ёнаго нисэх буудал



TOYOTA
Rent a Car

Тоттори нисэх буудал

Ёнаго нисэх буудал



NIPPON
RENT-A-CAR

Тоттори нисэх буудал

Ёнаго нисэх буудал



Times CAR
RENTAL

Тоттори нисэх буудал

Ёнаго нисэх буудал



NISSAN
Rent a Car

Тоттори нисэх буудал

Ёнаго нисэх буудал



Тоттори
Үнэгүй Wi-Fi үйлчилгээ
Tottori BB



Тоттори мужаас дотоод, гадаадын жуулчдад зориулсан олон нэвтрэх цэг бүхий үнэгүй Wi-Fi үйлчилгээг санал болгож байна. Дэлгэрэнгүй мэдээлэлтэй QR кодыг уншуулж танилцана уу.



Тоттори мужийн газрын зураг



Тоттори, Ёнаго чиглэлийн тээврийн үйлчилгээ

✈ Онгоц 🚆 Төмөр зам 🚌 Автобус

Тоттори чиглэл

Ханэда нисэх буудал	All Nippon Airways	80мин.	✈	Тоттори нисэх буудал
Кансай нисэх буудал	50мин. 🚆	Шин-Осака өртөө	150мин. 🚆	Тоттори өртөө
Хирошима нисэх буудал	50мин. 🚌	Хирошима өртөө	160мин. 🚆	
Фүкүока нисэх буудал	5мин. 🚆	Хаката өртөө	240мин. 🚆	
Осака Нанба / ОСАТ	180мин. 🚌			
Хирошима автобусны төв буудал	330мин. 🚌			

Ёнаго чиглэл

Ханэда нисэх буудал	All Nippon Airways	85мин.	✈	Ёнаго нисэх буудал
Инчeon олон улсын нисэх буудал	Air Seoul	90мин.	✈	Ёнаго өртөө
Хонконг олон улсын нисэх буудал	Hong Kong Airlines	220мин.	✈	
Шанхай Пүдонг олон улсын нисэх буудал	Juicyao Airlines	140мин.	✈	
Кансай нисэх буудал	50мин. 🚆	Шин-Осака өртөө	190мин. 🚆	
Хирошима нисэх буудал	50мин. 🚌	Хирошима өртөө	180мин. 🚆	
Фүкүока нисэх буудал	5мин. 🚆	Хаката өртөө	250мин. 🚆	
Осака Нанба / ОСАТ	220мин. 🚌			
Хирошима өртөөний шинкансэн гарц	220мин. 🚌			



Тоттори гэдэг нэр анх надад танил биш байв.

Харин тэнд намайг байгалийн үзэсгэлэнт газар, амтат зоог, адал явдал, дурсамж дүүрэн аялал хүлээж байлаа...



Тоттори мужийн албан ёсны вэб хуудас

Тоттори мужийн аялал жуулчлалын хөтөч
www.tottori-tour.jp/en/



Фэйсбүүк

Тоттори муж / 鳥取県

<https://www.facebook.com/tottoriprefecture/>



Инстаграм

Тоттори муж / 鳥取県

<https://www.instagram.com/tottoriprefecture/>

